



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/273

Булган сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйл, Иргэний хуулийн 64 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Х/14 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн Нөөцийн газар" ОНӨААТҮГ-ыг татан буулгаж "Хөдөө аж ахуйн хөгжлийн ирээдүй" ОНӨААТҮГ-тай нэгтгэх ажлын хэсгийн ахлагч Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга, Хууль эрх, зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Амар, Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Л.Лхамаа нарыг аймгийн нөөцийн газарт холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аймгийн Засаг даргыг бүх шатны шүүхэд бүрэн төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ